

ДОРНОД АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2018.03.23

Захирал Д.Должин
Удирдахуйн ухааны магистр, Эрүүл мэндийн
удирдлагын ахлах зэрэгтэй

Төлөөлөгч та бүхэнд өдрийн мэнд хүрье.

Манай байгууллага нь хэрэглэгчээ дээдэлсэн, өндөр чадавхитай эмнэлэг болох алсын хараатайгаар хүн амд эмнэлгийн мэргэшсэн лавлагаат тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлдэг

Нийт 500 эмч, ажиллагсадтай бөгөөд их эмч 104, сувилагч тусгай мэргэжилтэн 234, дэмжих үйлчилгээний ажилтан 150 байна.

Загвар БОЭТ болох Бельгийн төсөл 2008 оноос хэрэгжиж эхэлсэн тул энэхүү мэдээллийг тавихдаа статистикийн зарим үзүүлэлтийг төсөл хэрэгжсэнээс хойш сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан харуулахыг зорьлоо.

Дэлхий нийтийн жишигт эрүүл мэндийн байгууллагын хөгжил, хариуцлага, хүний нөөцийн чадварыг эх, хүүхдийн эндэгдлийн үзүүлэлтээр үнэлдэг. Манай эмнэлгийн түвшинд 2017 онд 1000 амьд төрөлтөд нялхасын эндэгдэл 7,5 байгаа нь 10 жилийн өмнөхөөс 1,9 дахин, хүүхдийн эндэгдэл 8,5 байгаа нь 2,4 дахин буурсан, эхийн эндэгдэл сүүлийн 5 жилд гаргаагүй ажилласан нь үйл ажиллагааны давуу тал юм.

Амбулаторийн үзлэгийн 25 кабинетаар жилд дундажаар 120 гаруй мянган хүнд үйлчилж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд нийт үзлэг 1,6 дахин өссөн, үзлэгт сумдын болон бусад аймаг хотын хүн амын эзлэх хувь жил бүр нэмэгдсэн, үзлэгийн 30 орчим хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. Амбулаторийн өдөр тутмын үзлэгээс гадна зорилтот үзлэгүүд болох хөдөлгөөнт эмнэлэгийн үзлэг, элэг бүтэн монгол, цэргийн үзлэг, даатгуулагчийн зорилтот насны үзлэг зэрэг тухайн цаг үеийн холбогдолтой үзлэгүүдийг нэмэлтээр хийж байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламжийн тухайд мэргэжлийн 14 тасагт жилд дундажаар 10000 гаруй үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хэвтэлтийн тоо 5,3 хувиар өссөн ч эмнэлэгт нас баралтын тохиолдол жил бүр буурсан байна.

Бид мэс заслын тусламж үйлчилгээг бүсийн хэмжээнд төдийгүй бусад аймгийн түвшинд тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхийг зорьж байна. Одоогийн байдлаар мэс заслын тусламж үйлчилгээнд дурангийн мэс заслын хагалгааны эзлэх хувь жил бүр өсч 2017 онд 6,2%-д хүрсэн байна. 2014 оноос эхлэн дурангийн мэс заслыг өргөтгөж цөсний хүүдийг авахаас гадна дурангаар мухар олгой авах, ивэрхий нөхөх, төмсөгний өргөссөн венийн судсыг тайрах, шамбарамын зангилаа тайрах зэрэг мэс заслыг хийхийн зэрэгцээ артери венийн судасны залгалт хийх, тойгны бяцарсан хугарал, бугалганы битүү хугарлыг засах, арьс нөхөх, шөрмөс сэргээх, хэнгэргэн хальс нөхөх, хамрын гадна хэлбэр, дэлдэн чих засах, нулимсны суваг залгах, нүдний хялар засах, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг нэвтрүүлэх зэрэг 11 төрлийн шинэ технологийг нэвтрүүлж байна.

ЭМЯ болон аймаг орон нутгийн дэмжлэгтэйгээр жил бүр шаардлагатай тоног төхөөрөмжүүд болох дурангийн мэс заслын багаж, хэрэгсэл (ЭМЯ, Орон нутгийн төсөв) газрын ариутгалын аппарат (Орон нутгийн төсөв), арьс нөхөх дерматомын багаж (Орон нутгийн төсөв), унтуулгын аппарат (ЭМЯ), амьсгалын аппарат (ЭМЯ) зэрэг тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлүүдийг үе шаттай байнга хийснээр дээрх шинэ технологиудыг нэвтрүүлэх боломж бүрдсэнийг онцлон дурьдахыг хүсч байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний салшгүй нэг хэсэг нь лабораторийн болон үйл оношийн шижилгээнүүд байдаг бөгөөд лабораторийн тусламжийн тухайд 2017 онд гематологи, биохими, иммунологийн шинжилгээний бүрэн автомат анализаторууд, мөн цусны электролитын анализаторийг шинээр суурьлуулснаар өмнө нь хийдэггүй байсан хавдрын маркерууд, бамбай булчирхайн гормоны шинжилгээ, бруцеллёзыг ялган оношлох зэрэг шинжилгээнүүдийг шинээр хийдэг болсон тул иргэдийн дунд ихээхэн хэл ам дагуулдаг байсан лабораторийн шинжилгээтэй холбоотой гомдол санал гарахаа больсон. Одоо шээсний болон цусны бүлэгнэлтийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй үздэг бүрэн автомат анализаторууд ирэх 7 хоногт суурьлагдахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Түүнчлэн үйл оношийн буюу багажийн шинжилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчийн тоо жил бүр өсч байна. Тухайлбал зүрхний ЭХО 10 жилийн өмнөхөөс 3,9 дахин, ерөнхий ЭХО 1,2 дахин, ЭКГ оношилгоо 1,7 дахин нэмэгдсэн байна. Энэхүү нэмэгдэж буй ачааллыг даван гарахад аймаг орон нутгийн төсвөөр шийдсэн 4D ЭХО, эмнэлгийн яаралтай тусламжийн багаж хэрэгсэл, шүдний бор машин зэрэг тоног төхөөрөмжийн шинэчлэл нь цаг үеэ олсон бодит дэмжлэг болсон байна.

Мөн жил бүр өсөн нэмэгдэж буй ачааллыг даван туулахад тоног төхөөрөмжийн шинэчлэлээс гадна мэргэшсэн чадварлаг эмч мэргэжилтэнтэй байх нь чухал тул хүний нөөцийг хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхааран ажиллаж байна. Аймгийн хөгжлийн сангийн 48,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр 2015 оноос эмч мэргэжилтнүүдийг гадаад сургалтад хамруулах ажил эрчимтэй явагдаж 30 эмчийг сургалтанд хамруулсанд манай эмч ажиллагсад талархалтай байна.

2016 оны 4 дүгээр сараас КТГ бүрэн зогссон нь бидний үйл ажиллагаанд тулгамдсан асуудал болж иргэдэд багагүй чирэгдэл учруулж байна. Дээд шатлалын эмнэлэгт 2016 оныг хүртэл жилд дундажаар 1600 гаруй хүнийг илгээж байсан бол сүүлийн 2 жилд 30 гаруй хувиар нэмэгдсэн байна. Үүнд дүн шинжилгээ хийж үзэхэд КТГ-ын оношилгооноос гадна элэг бүтэн монгол хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой элэг цөсний эмгэг, мөн хүүхдийн мэдрэл, зүрх судас, тархины судасны эмгэгүүдийн улмаас дээд шатлалд илгээгдэх өвчтөн зонхилох хувийн эзэлж байна. Харин осол гэмтлийн тохиодол нэмэгдсэн хэдий ч дээд шатлалд илгээгдэх хүний тоо төдийлөн нэмэгдээгүй байгаа нь осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээг орон нутагт боломжийн түвшинд үзүүлж байна гэж дүгнэхүйц байна. (тархи, нуруу нугасны гэмтлээс бусад)

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн тухайд дэлхий нийтэд төдийгүй монгол улсад 14 хүртэлх хоногийн хүлээгдлийг байж болох хүлээгдэл гэж үздэг боловч бидний хувьд бүх тусламжид 7-оос дээш хоногийг хүлээгдлийг гаргахгүй байхыг зорин ажилладаг.

Үзлэг оношилгооны 33 кабинетаар өдөрт 650 хүнд үйлчилж байгаа бөгөөд ачаалал ихтэй 25 кабинетад цаг товлох үйлчилгээгээр ачааллыг тэнцвэржүүлэн ажиллаж байна. Хүлээгдлийн гол шалтгаанд иргэд шатлал алгасаж үйлчлүүлэх, дугаар авсан цагтаа үйлчлүүлэгч ирэхгүй байх, зарим тохиолдолд тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл нөлөөлөхийн зэрэгцээ дээр дурьдсанчлан зарим үзлэг оношилгоонд хамрагдаж буй хүний тоо 1,2-3,9 дахин өссөн боловч эмч мэргэжилтний тоо сүүлийн 7 жилд огт нэмэгдээгүй, ДЭМБ-с зөвлөсөн 4500 хүн тутамд 1 шүдний эмч ноогдох стандартыг мөрдөх боломж байдаггүйтэй холбоотой шүдний тусламж үйлчилгээнд тогтолцооны гажуудал байгаа зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.


Гэсэн хэдий ч бид хүлээгдлийг бууруулж үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй сэтгэл ханамжтай тусламж үйлчилгээг үзүүлэхээр олон талт арга хэмжээг авч ажиллаж байна. Тухайлбал хүлээгдлийн мэдээг 7 хоног тутамд авч дүн шинжилгээ, зохицуулалт хийхийн зэрэгцээ хөтөч, цаг товлох үйлчилгээний журам, цаг олголтыг утсаар өгөх, цаг товлох үйлчилгээг цахимжуулахын зэрэгцээ үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хүлээгдлийг бууруулах зорилгоор 2014 оноос дараах тасаг кабинетуудыг нэмэлтээр байгуулан үйл ажиллагааг өргөжүүлсэн. Үүнд: хүүхэд, эмэгтэйчүүд, мэс засал, бөөр, элэг, ЭХО, өдрийн эмчилгээ, насжилт, вирус судлал зэрэг 11 кабинет, ЯТТ, МЭЭТ, нэгдсэн ариутгалын тасгуудыг өргөжүүлсэн зэргийг дурьдаж болно. Мөн үйлчлүүлэгчдийн хүлээх танхимуудыг стандартад нийцүүлэн зохион байгуулах, ажилтнуудынхаа ажиллах, хөгжих таатай орчин бүрдүүлэх зорилгоор сургалтын танхим, фитнес клуб, түүхэн алдрын танхим, ажиллагсдын ажлын хувцас угаалгын үйлчилгээг шинээр бий болгоод байна.

Өнөөдрийн байдлаар зүрхний ЭХО, зүрх судасны кабинет 3-6 хоногийн, ЭХО, мэдрэл, бөөрний кабинетууд 1-2 хоногийн хүлээгдэлтэй байгаа нь байж болох хүлээгдэл хэдий боловч иргэдийн бухимдлыг төрүүлж иргэдээс өргөдөл, санал гомдол гарсаар байна. Бид өргөдөл гомдлын бүтэц агуулагад тогтмол дүн шинжилгээ хийж, цаг тухайд нь шийдвэрлэн ажиллаж байна.

2017 оны байдлаар иргэдийн нийт хандалтаас талархал 9,1%, санал 19,8% хүсэлт 27,5% гомдол 43,6% тус тус эзэлж байгаа нь эмийн төсвийн хүрэлцээгүй байдал, хүлээгдэл, ачаалал, КТГ ажиллаагүй байдал зэргээс үүдэлтэй юм. Үүнээс шалтгаалж эмч үйлчлүүлэгчийн хооронд үл ойлголцол гарах, эмч нарыг хүнд сурталтай, зан харилцаа муутай гэж хэлэгдэх нөхцөл бүрдэж байна. Дээрх гомдол саналыг боломжит нөхцөл байдалдаа тулгуурлан тухай бүрт өөрсдийн хүрээнд шийдвэрлэн ажиллахаар үйлчилгээний соёлын журам гаргаж мөрдүүлэхийн зэрэгцээ “Эмч бид өөрчлөлтийг өөрөөсөө” уриан дор чөлөнж, ёс зүйн салбар хороо, нээлттэй утас зэргийг ажиллуулж эмч нарын харьцаа хандлагын эерэг байдлыг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.

Байгууллагын төсөв санхүүгийн бүтцийн дотор эмийн зардал 13,4%, урсгал засвар 0,3% эзэлж байгаа нь төсвийн бүтцийн гажуудал байгааг харуулж байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл /хувиар/



Сүүлийн 4 жилд багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд: ЭМЯ-ны болон хандив тусламжаар 2,520,6 сая төгрөг аймаг орон нутгаас нийт 461,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь үйл ажиллагааг тасралтгүй явуулахад томоохон түлхэц болсоныг дурьдаж НӨУЁБ, гүйцэтгэх засаглалын удирдлагууд та бүхэнд талархаж байна.

Манай ихэнх тоног төхөөрөмжүүд насжилт өндөртэй болж байнга эвдрэл гэмтэл гарч тухай бүрт нь засаж хэвийн үйл ажиллагаанд оруулахад хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай болдог хэдий ч эмнэлэгийн төсөвт автомашин, тоног төхөөрөмж, сантехник бусад урсгал засварын зардалд сар бүр 500 мянган төгрөг л төсөвлөдөг нь маш хангалтгүй юм. Тиймээс бид зөвхөн дээрээс ирэх дэмжлэг, батлагдсан төсвийг харалгүйгээр өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлж тулгамдсан асуудлыг шийдвэрлэн ажиллахыг хичээдэг.

Тухайлбал сүүлийн 4 жилд урсгал засварт 101,4 сая төгрөг, нэн шаардлагатай жижиг багаж хэрэгсэл авахад 105,5 сая төгрөг зарцуулах зэргээр нийт 388,8 сая төгрөгийг нэмэлтээр олж байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаа.

Гэвч бидний дотоод нөөц боломждоо тулгуурлан шийдвэрлэх боломжгүй дараах тулгамдаж буй асуудлууд байсаар байгаад эрхэм төлөөлөгчид та бүхнийг анхаарлаа хандуулж бодлогын дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

Үүнд:

1. Эмийн төсвийн хүрэлцээгүй байдал, ДЭМБ-с нийт төсвийн 17-21%-г эмийн төсөв эзлэх ёстой гэсэн хэдийн манайд 13,4% эзэлж байна.
2. Тоног төхөөрөмжийн хангамж, шинэчлэлтэй холбоотой нэн тэргүүнд КТГ аппарат, цаашилбал дуплекссонографийн болон дурангийн оношилгооны аппарат, дурангийн мэс заслын багаж хэрэгсэл, рентген аппарат, автоклав зэргийг шийдэх хэрэгтэй байгаа.

3. Хэрлэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэвшлийн эмнэлэгүүдээс гарч буй эмнэлгийн гаралтай хог хаягдлыг манай эмнэлэгт халдваргүйжүүлж эцсийн хог хаягдал болгодог тул хог хаягдлын нэгдсэн байгууламж зайлшгүй шаардлагатай байна.

Дүгнэлт:

Давуу талаас дурьдвал:

1. Эхийн эндэгдэлгүй болон хүүхдийн эндэгдлийг бууруулсан үзүүлэлтээр өрсөлдөх чадварын индексээр улсдаа тэргүүлж байгаагийн зэрэгцээ төрөлтийн ерөнхий коэффициент, хүн амын цэвэр өсөлт, жирэмсэний хяналтаар тус бүр 3-р байранд эрэмблэгдсэн нь шат шатны эрүүл мэндийн байгууллагдайгаа хамтарч болон дангаараа бидний оруулсан хувь нэмэр чамгүй их гэж үзэв.
2. Мэс заслын хагалгаанд дурангийн мэс заслын эзлэх хувь 6,9 байгаа нь аймгуудын дундажаас 2%-иар өндөр байна.
3. Сүүлийн 4 жилийн хугацаанд 30 гаруй нэр төрлийн шинэ техник, тоног төхөөрөмж суурьлуулан тусламж үйлчилгээ тасралгүй үзүүлэхийн зэрэгцээ төрөлжсөн мэргэжлийн 10 кабинет 2 тасгийг шинээр зохион байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлжээ.
4. Ижил түвшний эмнэлэгүүдэд төдийлөн хийгддэггүй вирус судлалын шинжилгээ, тархины цахилгаан бичлэг, булчин мэдрэлийн цахилгаан бичлэг зэрэг 6 нэр төрлийн тусламж үйлчилгээг орон нутагт үзүүлж байна.
5. Эмч ажиллагсдынхаа ажиллах, сурч хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилгоор сургалтын танхим, фитнес клуб, түүхэн алдрын танхим зэргийг шинээр байгуулсан
6. Эмч нарын 98% үндсэн мэргэшил эзэмшсэн, 44,6% нь төрөлжсөн мэргэшил эзэмшсэн, эмнэлгийн мэргэжилтний 30,2% мэргэжлийн, 15,3% боловсролын зэрэгтэй, 15,4% Клиникийн профессор цолтой чадварлаг багаар тусламж үзүүлж байна.
7. Төсөв санхүүгийн өмнө хүлээсэн үр дүнгээр сүүлийн жилүүдэд санхүү аудитын хяналтаар “зөрчилгүй” санал, дүгнэлттэй, 2016 онд итгэмжлэл авч ажилласан
8. Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр БОЭТ-үүдийн түвшинд сүүлийн 3 жилд I-II дугаар байрт дүгнэгдсэн байна.

Сул талын тухайд:

1. Өрсөлдөх чадварын индекст эрүүл мэндийн салбарын дэд бүтэцээр 20, Халдварт өвчний тархалтаар 21-р байранд орсон нь бидэнтэй шууд хамааралтай бус ч сул тал гэж дүгнэлт хийж байна.
2. КТГ-гүй, шүдний тусламж үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна.
3. Иргэд тусламж үйлчилгээнд цаг товлолтыг ойлгохгүй, хүлээн авахгүй шатлал алгасах, товлот цагтаа ирж үйлчлүүлэхгүй байна.
4. Зарим тохиолдолд эмч, мэргэжилтний харьцаа хандлага, цаг ашиглалт сул, мэдээлэл тодорхой бус байна.

Бид дараах зорилтыг цаашид хэрэгжүүлнэ:

1. Мэс заслын тусламж үйлчилгээнд бөөр шээсний замын дурангийн мэс заслын шинэ технологи нэвтрүүлэх
2. Тархины судасны эмгэгийн оношилгоонд дуплекссонографийн шинжилгээг шинээр нэвтрүүлэх
3. Хүүхдийн мэдрэлийн өмчийн мэргэшсэн тусламж, хүүхдийн зүрхний ЭХО оношилгооны тусламжийг үе шаттай нэвтрүүлэх

4. Хүн амын өсөлттэй уялдуулан шүдний тусламж үйлчилгээг өргөжүүлж 2-3 эмчийг нэмэлтээр ажиллуулах
5. Сүрьеэ, БЗДХ-ын мэргэшсэн багийг бүх сумдад жилийн турш ажиллуулах
6. Үйлчлүүлэгсдийн дунд сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх сургалт мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулах
7. Төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллага болох
8. Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар албан даалгаврын хүрээнд өгсөн үүргийг өдөр тутамдаа хэвшил болгох
9. Эмч бид өөрчлөлтийг өөрөөсөө эхэлнэ зорилтот жилийн хүрээнд хандлагаа сайжруулан ажиллах болно.

Тусламж үйлчилгээг хүлээгдэл чирэгдэл багатай чанартай хүртээмжтэй үзүүлэхийг зорьж манай эмч, ажилтнууд амралт, баяр ёслол, өдөр шөнийг эс ялган, хоёргүй сэтгэлээр ажиллаж, эдгэрсэн хүнээ харж сэтгэл баясдаг, тавилан буруу эргэсэн тохиолдолд сэтгэл нь өмөрч дотроо уйлдаг хэдий ч хүн амын өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээ, улс орны нийгэм, эдийн засгийн таагүй нөхцөл байдал, хувь хүний амьдралын буруу зан үйл зэрэг олон шалтгаан, хүчин зүйлтэй холбоотойгоор бид дангаараа шийдвэрлэх боломжгүй тулгамдсан асуудлууд байсаар байна.

Иймд та бүхнийг олон талт хамтын ажиллагааны үр дүнд шийдвэрлэгдэх зайлшгүй шаардлагатай байгаа дээрх асуудлуудыг анхааралдаа авч бодлогын дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Манай салбарын талаар сонсгол сонсох санаачлага гарган бидний тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэж, дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байгаа төлөөлөгч Я.Насандэлгэр танд талархая.

Эр хүнийг та нар хааяа ч гэсэн хайрла гэж нэгэн яруу найрагчийн тэрлэсэн шиг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг минь хааяа ч гэсэн хайрлаж ойлгоосой гэж та бүхнээс хүсье.

Баярлалаа.